

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 3 удаа хуралдан 10 гаруй асуудал хэлэлцэн 17 тогтоол батлав. Үүнд:

-Аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, техник технологийн шинэчлэл хийж тогтвортой амжилт гаргаж байгаа Түшиг сумын “Бооцын тариа”, Цагааннуур сумын “Ургацын хишиг”, Цагааннуур сумын “Товхон хан” ХХК-иудыг “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-оор шалгаруулан шагнуулахаар Монгол улсын Засгийн газарт уламжлалаа.

-Мөнгө газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалтыг богино хугацаанд чанартай хийж гүйцэтгэн амжилт гаргасан механикжуулагч, мал сүргээ өсгөн үржүүлэх ажилд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулсан зарим иргэдийг “Улсын тэргүүний тариаланч”, “Улсын сайн малчин”-аар шалгаруулан шагнуулахаар Монгол улсын Засгийн Газарт уламжлалаа.

-Аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд эрчимжсэн мал аж ахуй эрхлэн өндөр ашиг шимт сүү-махны чиглэлийн Алатау үүлдрийн 73-105 үхрийг өсгөн үржүүлж, жил бүр 34-46 үнээг саалинд хамруулж 74.7-122.2 мянган литр сүү үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, нэг үнээнээс 2440 л сүү саасан, жилдээ 85.1 сая төгрөгийн борлуулалт хийсэн зэрэг амжилтыг үнэлж Баянгол сумын фермер Нянгарын Отгондоржийг “Улсын тэргүүний фермер”-ээр шалгаруулан шагнуулахаар Монгол улсын Засгийн газарт уламжлалаа.

-Аймгийн нутаг дэвсгэрт 2016 онд ойгоос бэлтгэх модны төрлөөр тогтоосон дээд хязгаар, огтлолын төрлөөр тогтоосон дээд хязгаар, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойн санд явуулах цэвэрлэгээний огтлолын талбай, бэлтгэх модны дээд хязгаарыг, “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийн хүрээнд бэлтгэх модны дээд хязгаарыг тус тус сум бүрээр баталлаа.

-2016 онд аймгийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг сум тус бүрээр батлан гаргалаа.

Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8, Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг үндэслэн Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг явуулахад аймгийн төвийн сумын баг тус бүрийг 1, бусад сум тус бүрийг 1 тойрог болгон нийт 24 тойрог байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт Төлөөлөгчдийн тоог 37 байхаар тогтоолоо.

Аймгийн Засаг даргын саналыг үндэслэн Зүүнбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгийн балансад бүртгэлтэй 2010 онд Япон улсад үйлдвэрлэгдсэн “Ниссан Урбан” маркийн автомашиныг 2004 онд Япон улсад үйлдвэрлэгдсэн “Ниссан Х-трайл” маркийн автомашинаар солихыг зөвшөөрлөө.

Мандал суманд үйл ажиллагаа явуулж байгаа Есүс Христийн “Амьд чулуу чуулган” шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар сунгалаа.

Эрхэлсэн салбартаа хөдөлмөр бүтээлийн амжилт гаргасан зарим хүмүүсийг “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 1, “Алтан гадас одон”-оор 1, “Цэргийн гавьяаны одон”-оор 1, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 2 хүмүүсийг шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжлалаа.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас 2016 онд “Хүнээ хөгжүүлж, үйлдвэрлэгчдийг дэмжих жил” бодлогын зорилт дэвшүүлэн, Зарласан жилийн хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд бүтээлч санаачлага, бодит үр дүн гаргаж ажиллахыг аймгийн нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад уриаллаа.

2014 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн Монгол Улс, Оросын холбооны Улсын засгийн газар хоорондын хэлэлцээрээр 2 улсын иргэд харилцан визгүй зорчиж, хилийг 24 цагийн горимд шилжүүлснээр хилээр гарах 2 улсын иргэдийн тоо харьцангуй нэмэгдэж улс хоорондын болоод хил залгаа аймгуудын цаашдын хөгжил, чиг хандлагад таатай орчныг бүрдүүлж өгсөн. Харин нийтээр тэмдэглэх баяр ёслолын үед Оросын холбооны улсруу хил нэвтрэх иргэдийн тоо харьцангуй нэмэгдэн урт очер дараалал үүсч, хяналт, шалгалтын байгууллагуудын үйл ажиллагааны давхардал зэрэг нь иргэдэд ихээхэн бухимдал үүсгэж байгаа тул аймгийн Засаг дарга тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Алтанбулаг хилийн боомт дээр ажиллаж хяналт, шалгалтын байгууллагуудын удирдлага, ажилтнуудтай нэгдсэн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уулзалтаар шаардлагатай зарим арга хэмжээг азар дээр нь авч хэрэгжүүлж, шийдвэрлэх боломжгүй байгаа асуудлуудыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжиллаа.

Аймгийн хэмжээнд цас их орж, хүйтэрч, цаашид өвөлжилтийн байдал хүндэрч болзошгүй байгаа тулаймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга сумдын өвөлжилтийн байдалтай газар дээр нь танилцан, малчин, мал бүхий иргэдтэй уулзаж, тэдний санал хүсэлт, тулгамдаж буй асуудлуудыг сонсон, шийдвэрлэх арга замын талаар санал солилцлоо.

2015 онд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан онцлог мэдээллүүдийн талаарх 2016 оны “Цаг тооны бичиг-ийг хийн, нийт 1000 ширхэгийг хэвлүүлж, хүлээн авлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, орон нутгийн “Шинэ гэгээ” сонины газартай хамтран гаргадаг “Өргөн сэлэнгэ” сонины 1 дүгээр сарын дугаарыг хэвлэн, иргэдэд хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын орлогч Н.Батдорж 2016 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр шинэ оны эхний сард хийж, хэрэгжүүлсэн ажил, төв, орон нутгийн өвөлжилтийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нартай уулзалт зохион байгуулж, мэдээллүүдийг авч хэлэлцлээ.

Монгол Улсын Хилийн тухай хууль, Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Иргэдийг улсын хил хамгаалалтад оролцуулах тухай” журмын хэрэгжилтийг хангаж, хил хамгаалалтад иргэд, байгууллагуудын идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хил хамгаалах туслах хүчний нэгдсэн зөвлөлгөөнийг 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газар, хилийн 0243 дугаар анги хамтран зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс “Төсөв санхүүгийн талаар баримтлах бодлого, цаашид анхаарах асуудлууд” сэдвээр сумдын төрийн сангийн төлөөлөгч, мэргэжилтэн нарт 2015 оны 1 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд сургалт зохион байгууллаа. Сургалтаар 2015 оны төсвийн гүйцэтгэлийн товч мэдээлэл, 2016 оны төсвийн хандлага, Санхүүгийн албаны ажиллах чиглэл, төрийн сангийн дотоод хяналт, илэрч буй нийтлэг зөрчлүүд, “Манлайлагч санхүүгийн алба” аяны удирдамж, аж ахуйн нэгж байгууллагын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаар мэдээлэл хийлээ.

Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөр, Орон нутгийн Цогц хөгжил-Түншлэл төслийн санхүүжилтээр 2015 онд аймгийн төр, захиргааны байгууллагуудын албан хаагчдад зориулсан шаталсан сургалтуудад хамрагдаж болзол хангасан төрийн албан хаагчдад сертификат гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгууллаа.

Сар шинийн баярыг угтан аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран 2015 оны 1 сарын 29, 30-ны өдрүүдэд “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулж, нийт сумдын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид өргөн бүрэлдэхүүнтэйгээр оролцож, иргэд хөдөлмөрчдөд өргөнөөр үйлчиллээ.

Онцгой байдлын газар:

Шинэ жил нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд Төрийн захиргааны байгууллага⁸, Галын онц аюултай объект⁴, үзвэр үйлчилгээ², төвлөрсөн зах, худалдааны төв³⁵, спортын ордон³, ресторан, кафе, шөнийн клуб¹⁵, боловсролын байгууллага⁷, нийт 74 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 205 зөрчил илрүүлж, 11 зөрчлийг үзлэг шалгалтын явцад арилгуулж, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 26, мэдэгдэл 42, ажиллагаа зогсоох тогтоол 1, гал түймэр гарсан тухай акт 5, зөрчлийн тэмдэглэл 4 үйлдлээ.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сум дахь Гал унтраах, аврах анги, улсын нөөцийн салбар, Эрэн хайх, аврах ангийн бие бүрэлдэхүүн 161 аж ахуйн нэгж байгууллагын 427 ажилтан албан хаагчдад пиротехникийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны талаар заавар зөвлөмж өгч сэрэмжлүүлэгийн материал тарааж, дээрх сумдын 1333 айл өрхийн 4740 иргэнд шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх үедээ пиротехникийн хэрэгсэл ашиглах, цахилгаан хэрэгсэлийн болон пийшин зуухны галлагааны аюулгүй байдлыг хангаж ашиглах талаар сэрэмжлүүлэг материал тараан заавар зөвлөмж өглөө.

2016 оны 1 дүгээр сард 12 удаагийн объектын гал түймэр гарснаас 4 гал түймэр мэдээллээр ирж, гал түймрийн улмаас 54.095.000 төгрөгийн хохирол учирсан. Гал унтраах, аврах ангиуд нийт 8 удаагийн объектын гал түймрийн дуудлагаар ажиллаж, 8 гал түймрийг 14.6 тн ус, 118.8 литр шатахуун зарцуулан унтрааж, гал түймрийн аюулаас аж ахуйн нэгж, байгууллагын 82.7 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгааллаа. Гал түймрийн шалтгаан нь цахилгаан ашиглалтын буруугаас 3, пийшин зуухны яндангийн цоолтоос 3, ил задгай галаас 4, тамхи шүдэнзний галаас 1, санаатай үйлдлээр 1 удаа тохиолдсон.

НҮБ-аас хэрэгжүүлж буй “Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдлийг бууруулах менежмент зохицуулалтын чадавхийг сайжруулах нь МОН/13/31/ төслийн багтай хамтран Алтанбулаг сумын сайн дурынхан, иргэдэд “Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах чадварт сургах” сэдэвт сургалтыг зохион байгуулж тус сумын 56 иргэд, сайн дурынхныг хамрууллаа.

Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран Алтанбулаг, Шаамар, Дулаанхан, Зүүнбүрэн сумдын Ерөнхий боловсролын сургууль, Шаамар сумын Мэргэжилт сургалт үйлдвэрлэлийн төвд “Өсвөрийн аврагч” клубыг сургуулийн захирлын тушаалаар байгуулан клубын гишүүдийг чадавхижуулах сургалтыг онцгой байдлын газар дээр зохион байгууллаа.

Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:

Сэлэнгэ аймгийн хилийн цэргийн 0243-р ангийн 7 заставын дарга, буудлын эрхлэгч нарт "Хоолны газрын ангилал зэрэглэл, Хоолны газрын нийтлэг журам", "Хүнсний агуулах" сэдвээр мэдээлэл өгч, сургалт зохион байгуулан цаашид цэргийн ангийг стандартын шаардлага хангуулах ажлыг эхлүүлж, хамтарч ажиллахаар шийдвэрлэлээ.

Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс Спирт бал бурам ХХК-ийн удирдлагын тогтолцоонд "Чанарын удирдлагын тогтолцоо. MNS ISO 9001:2010 стандартын дагуу магадлах аудит, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо MNS ISO 22000:2007 стандартын дагуу давтан аудит хийлээ.

Мандал, Сүхбаатар, Алтанбулаг сумын 8 худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийж, сумдын баталгаажуулалтын орон тооны бус салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр худалдаа, үйлчилгээний газрын мөрдвөл зохих стандартын 84.0-өөс дээш хувийг хангасан 4 худалдаа, үйлчилгээний газарт, тохирлын гэрчилгээ олголоо.

Сүхбаатар сумын 4-р багт байрлах "Хишиг" цехийн 2 нэрийн 2 бүтээгдэхүүний сав баглаа хаяг шошгыг холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлүүлж, аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимаас үйлдвэрлэж буй бүтээгдэхүүндээ зураасан код авахад нь холбогдох арга зүйн заавар өглөө.

Стандартын салбар сангаас 7 аж ахуй нэгж, иргэний хүсэлтийн дагуу 7 нэрийн 8 стандартаар хангаж, арга зүйн зөвөлгөө өгч, үйлчилгээ үзүүллээ.

Сүхбаатар сумын худалдаа үйлчилгээнд ашиглаж байгаа 53 жин, айл өрх, аж, ахуй нэгж, байгууллагын төлбөрийн тооцоонд ашиглагдаж байгаа 1 фазын 1468 ширхэг цахилгаан тоолуур, "Дашваанжил" ХХК-ийн авто химийн цахилгаан станцын 2 хийн түгээгүүрийг баталгаажуулж, Мал эмнэлэгийн сорилтын лабораторийн 3 электрон жинд шалгалт тохируулга хийлээ.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	15,260,839.7	14,592,426.3	95.6
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	12,179,612.5	10,978,974.7	90.1
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	27,788,181.6	24,151,752.5	86.9
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	16,094,347.7	13,848,083.5	86.0
	-Аймгийн ОНХСангийн зарцуулалт	2,173,410.9	1,748,465.2	80.4
	-Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	378,900.0	204,233.6	53.9
	-Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,042,904.6	622,662.3	59.7
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	4,450,072.6	3,709,655.1	83.4
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	5,502,800.0	5,325,439.3	96.8
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	39,110,508.5	38,631,563.0	98.8
	- Ерөнхий боловсролын сургууль	20,265,931.3	20,044,897.2	98.9
	- Хүүхдийн цэцэрлэг	9,868,232.7	9,868,232.7	100.0
	-Эрүүл мэнд, спортын байгууллага	5,418,579.2	5,258,277.6	97.0
	-Соёлын байгууллагуудын	2,998,873.5	2,913,344.4	97.1
	-Газрын харилцаа кадастрын алба	245,253.8	241,557.9	98.5

	-Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	313,638.0	305,253.2	97.3
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	39,110,508.5	38,631,563.0	98.8
	-Ерөнхий боловсролын сургууль	20,265,931.3	20,102,348.7	99.2
	-Хүүхдийн цэцэрлэг	9,868,232.7	9,810,781.2	99.4
	-Эрүүл мэнд	4,719,774.9	4,579,257.6	97.0
	-Спортын байгууллага	698,804.3	679,020.0	97.2
	-Соёлын байгууллагуудын	2,998,873.5	2,913,344.4	97.1
	-Газрын харилцаа кадастрын алба	245,253.8	241,557.9	98.5
	-Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	313,638.0	305,253.2	97.3
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4,977,575.9	4,838,978.0	97.2
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2,436,670.2	2,028,907.5	83.3
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	1,683,153.7	1,335,346.7	79.3
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	623,634.4	622,637.0	99.8

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2015 XI- сар	2015 XII- сар	<u>2015-XII</u> <u>2015-XI</u>
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа			
	Гурил /савласан, кг/	1200	1200	100
	Талх /орон нутгийн, ш/	1100	1100	100
	Нарийн боов /кг/	2300	2300	100
	Будаа /кг/	2200	2200	100
	Элсэн чихэр /кг/	1800	1800	100
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	4000	3800	95.0
	Үхрийн мах /кг/	5000	5000	100.0
	Адууны мах /кг/	4000	4000	100.0
	Ямааны мах /кг/	3500	3000	85.7
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	3000	75.0
	Хиам /чанасан, кг/	9500	9500	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1000	1000	100
	Сүү / савласан, л/	2500	2500	100
	Тараг /задгай, л/	1200	1200	100
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	10000	10000	100
	Айраг /л/	3500	3500	100
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	100
	Өндөг /ш/	280	280	100
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	3400	3400	100
	Өөхөн тос /кг/	1500	1500	100
	Шар тос /кг/	9000	9000	100
	Масло /задгай, кг/	5000	5000	100
5	ХҮНСНИЙ НОГОО			

	Төмс /кг/	1000	1000	100
	Лууван /кг/	1500	1500	100
	Манжин /кг/	2000	2000	100
	Байцаа /кг/	1500	1500	100
	Сонгино /кг/	2000	2000	100
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3000	3000	100
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2500	2500	100
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1590	1590	100
	Бензин А - 92	1690	1690	100
	Дизелийн түлш	1830	1830	100

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1. Архивын талаар:

Аймгийн Төрийн архивын 2015 оны хяналт шалгалтын ажлын тайланг Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

“Ажлын цаг” ХХК-ийн гүйцэтгэсэн Мандал сумын доторх гудамж замын гэрэлтүүлгийн зураг төслийн баримт бичгийг хүлээн авч сан хөмрөгт байрлууллаа.

Мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт албан хаагчдад “Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Шаамарын тэжээлийн аж ахуйн 1968-1990 оны, мөн Цагааннуур сумын Худалдаа бэлтгэлийн анги Өгөөмөр хэрэглээний хоршооны 34 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг Орхон сангийн аж ахуйн 18, Цагааннуур сумын худалаа бэлтгэлийн ангийн 34, Шаамарын тэжээлийн аж ахуйн 23 хадгаламжийн нэгж, нийт 75 хадгаламжийн нэгжид бүрэн хэлбэрээр хийлээ. Мөн сэлбэн засалтын ажлыг Цагааннуур сумын Худалдаа бэлтгэлийн ангийн 18 хуудас баримтанд хийлээ.

Төрийн архивын AMS программд Орхон сангийн аж ахуйн 1970-1980 оны 12 хадгаламжийн нэгжний 1844 хуудасны агуулгыг уншиж 1220 заалт, 11235 хүний нэр, 37 байгууллагын нэр, 87 газар зүйн нэрийг шивж оруулсан. Мөн тус хөмрөгийн 20 хадгаламжийн нэгжийн 3738 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэлээ.

Мастер хувиас ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 52 хадгаламжийн нэгжийн 9543 хуудас баримтыг photoshop программ ашиглан ашиглалтын хувь үүсгэлээ.

Иргэд албан байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу архивын хуулбар 165, архивын магадлагаа, тодорхойлолт 45, эхийн одонгийн лавлагаа 4 гаргаж үйлчиллээ.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Боловсролын чиглэлээр:

Аймгийн Боловсрол, соёлын газраас бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилт, суралцахуйн зорилт, ээлжит хичээлийн уялдаа холбоо нь зорилгод хүрч буй эсэхийг ажиглах, сайжруулах сургалт, хэлэлцүүлэгийг 2016 оны 1 дүгээр сарын 07-09-ний өдрүүдэд бүсчлэн Ерөө бүсийн ерөнхий боловсролын 8 сургуулийн 157 багшийг оролцуулан зохион байгуулж, заах арга зүй, ур чадварыг дээшлүүллээ.

БСШУЯ-аас зохион байгуулсан “Ахлах сургуулийн сургалтын цөм хөтөлбөрийн туршилт, хэрэгжилтийн бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт сургалтад 2016 оны 01 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд аймгийн Боловсрол, соёлын газрын мэргэжилтнүүд, лаборатори сургуулийн захирал, сургалтын

менежерүүдийн хамт оролцож, ахлах ангийн сургалтын цөм хөтөлбөрийн түгээн дэлгэрүүлэлтийн төлөвлөгөөний төслийг бэлтгэж, туршилтын хөтөлбөрөөр хичээллэж байгаа сургууль дээр туршлага судлалаа.

БСШУЯ, Монголын оюутны холбоо хамтран 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?” сэдэвт лекцэнд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1,2,3,4 дүгээр сургуулийн 280 сурагчийг хамрууллаа.

2. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1643 иргэнд 207,3 сая төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 908 иргэнд 60,2 сая төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 26 иргэнд 4,6 сая төгрөгийг тус тус олголоо.

Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжинд 560 иргэнд 34,6 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 48 иргэнд 2394,0 мянган төгрөгийн тусламж хөнгөлөлт үйлчилгээг, жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 1049 эхэд 38.9 сая төгрөгийг тус тус олголоо.

Алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 22 иргэнд 3,5 сая төгрөгийг олголоо.

3. Нийгмийн даатгалын талаар:

2016 оны 1 дүгээр сарын 29-ний байдлаар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангуудад 1773.34 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 1601.32 сая төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 90.3 хувьтай байна.

Тэтгэвэрийн даатгалын сангаас 14536 тэтгэвэр авагчдад 3913.90 сая төгрөгийн тэтгэвэр олголоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас 213 даатгуулагчдад 121.57 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын, тэтгэмж олголоо.

Үйлдвэрлэлийн осол, мэргэшлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 317 даатгуулагчид 84.6 сая төгрөгийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн ослын тэтгэмж, сувилалын зардалд олголоо.

Ажилгүйдлын даатгалын сангаас 21 даатгуулагчдад 26.72 сая төгрөгийн ажилгүйдлын тэтгэмж олголоо.

4. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2015 оны 12 дугаар сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 798 байсан бол 124 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 25 ажлын байранд 15 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 93 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 814 боллоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төрийн банкаар дамжуулан малчин хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд олгож буй жижиг зээлд Баянгол, Сүхбаатар сумын 2 иргэнд 6000,0 мянган төгрөгийн зээлийг олгон 4 ажлын байрыг шинээр бий болголоо.

Аж үйлдвэрийн сайд, Хөдөлмөрийн сайдын “Чиг үүрэг шилжүүлэх тухай” 2015 оны 65/А/40 тоот хамтарсан тушаалыг хэрэгжүүлж Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтнүүдийг албан хэрэгцээнд хэрэглэгдэж буй үндсэн хөрөнгийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газарт шилжүүллээ.

Цас ихээр орж, замын халтиргаа гулгаа ихсэж осол гарах аюултай нөхцөл байдал үүсч байгаатай холбогдуулан Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлөөс сургалт зохион байгуулж, төрийн албан хаагчид болон иргэдийг хамрууллаа.

5. Эрүүл мэнд, хүүхэд залуучуудын талаар:

Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсээс Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх иргэдэд зориулсан сургалтыг 2015 оны 01 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Онлайн орчин дахь хүүхэд хамгаалал ба кибер дарамт, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх талаар Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд 12 жилийн сургуулийн 600 гаруй хүүхдэд сургалт зохион байгууллаа.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/10 дугаар тушаалаар өрх гэр бүлийн гишүүн бүрийн идэвхи санаачлагыг өрнүүлэх зорилгоор хүүхэд бүрийн оролцоог дэмжсэн “Миний гэр бүл” хөгжлийн хөтөлбөрт аймгийн нийт ерөнхий боловсролын сургуулийн зорилтот бүлийн 10-17 насны нийт 1000 хүүхэд, тэдний гэр бүлийг хамруулан ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын хяналтанд байдаг архины хамааралтай, удаа дараа эрүүлжүүлэгдсэн 20 иргэнд “Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ?” сэдвээр мэдээлэл хийлээ.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсээс “Цодгор хүү-2016” аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 9 сумын 120 шатарчид, 4 насны ангиллаар хийлээ.

Өрх, сумын эмч, эмнэлгийн мэргэжилтний сургагч багш бэлтгэх сургалтанд 3 эмч мэргэжилтэн хамрагдан бэлтгэгдэж, аймгийн нийт сум, тосгодын Эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдэд “Хүүхдийн өвчлөлийн цогц менежмент” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, нийт 58 эмч мэргэжилтэн хамрагдлаа.

Тав. Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн тэргүүний тариаланч хамт олноор Ерөөсумын “Сэлэнгэ тариа” ХХК, Цагааннуур сумын “Шүрэн тариа” ХХК, аймгийн тэргүүний тариаланчаар Баруунбүрэн сумын “Орхондалай” ХХК-ийн механикжуулагч Х.Зоригтбаатар, Цагааннуур сумын “Шаргал тариа” ХХК-ийн механикжуулагч Д.Ууганбаяр нарыг шалгарууллаа.

Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын судалгааг гаргалаа. Аймгийн хэмжээнд 175 аж ахуйн нэгж, иргэд үйл ажиллагаа явуулж байгаагаас 12 ресторан, 25 зоогийн газар, 19 кафе, 6 баар, 33 гуанз, 99 гал тогоонд 595 ажилтан, 6962 хүнийг хооллох багтаамжтай хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрууд ажиллаж, жилд 794.6 сая төгрөгний борлуулалт хийж байгаа дүнтэй байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газартай хамтран Монгол улсын Засгийн газрын 2015 оны 480 дугаар тогтоолын дагуу Улсын нөөцөд 2011-2013 онд бүрдүүлсэн өвсний нөөцөөс буцалтгүй тусламж хэлбэрээр олгож буй өвснөөс 250 тн өвсийг аймгийн нийт сумдад хуваарилах ажлыг зохион байгууллаа.

1350 кг адууны махны 9 дээж, үхрийн 3800 кг махны 27 дээж, хонины 1950 кг махны 77 дээж, тэмээний 200 кг махны 1 дээж, сүүний 6 дээжинд 340 л сүү МЭАЦ-ийн нийт 7300 кг махны 114 дээж магадлан шинжилгээ хийж баталгаажуулалт олголоо.

Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:

1. Газрын харилцааны талаар:

Аймаг, сумын газар зохион байгуулалтын 2015 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2016 оны төлөвлөгөөг сумдаас хүлээн авч 2016 онд иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлы Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулж, иргэнд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг сумдын газрын даамлуудад үүрэг чиглэл өгөн ажиллаж байна.

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, кадастрын эрх бүхий байгууллага болох Хас марк ХХК, Сод сүрвэй ХХК-иудын хамтарсан уулзалтыг зохион байгуулж иргэдийн газар өмчлөх эрхийн болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг хийхэд тулгарч буй саад бэрхшээл үл ойлголцлыг нэг чиг баримтлалаар иргэнд үйлчилгээ үзүүлэх, газрын кадастрын зураг, барилга байгууламжийг улсын комиссоор хүлээн авсан тухай актын талаар тодорхой ойлголтод хүрч, санал солилцлоо.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 27 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж баталгаажууллаа.

2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:

Алтанбулаг сумын нийгмийн даатгалын барилга дээр улсын комисс ажиллаад үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээн авлаа.

Сүхбаатар сумын 5-р багийн 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга дээр улсын комисс ажиллаж мөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээн авав. Хавар дулаан орохоор гадна тохижилт, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэнэ.

Эрчим хүчний яаманд Сайхан сумын “Цахилгаан сүлжээ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг сунгуулах талаар хүсэлт гаргалаа.

Мандал сумын Түнхэл тосгонд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зургийг ажлын зургийг хяналаа..

3. Байгаль орчны талаар:

2016 оны 1 дүгээр сарын 1, 2, 9-нд ихэнх сумдын нутгаар 0,0-4,0 мм, 3-нд нутгийн баруун хэсгээр, 4, 6-нд нутгийн зүүн хойд хэсгээр, 10-нд Бугант, 13-нд Ерөө, 19-нд Орхон сумдын нутгаар 0,0-3,0 мм цас орлоо. Бусад хугацаанд цас ороогүй. Ихэнх хугацаанд салхи зүүн өмнөөс болон баруунаас 3-8 м/сек байлаа.

1-р арав хоногт шөнөдөө 25-30 градус, өдөртөө 12-17 градус, 2-р арав хоногийн эхэн болон дунд үеэр шөнөдөө 28-33 градус, өдөртөө 17-22 градус байлаа. 2-р арав хоногийн сүүлээр хүйтэрч шөнөдөө 36-41 градус, өдөртөө 22-27 градус хүйтэн байлаа.

Нийт сумдын нутгаар битүү цасан бүрхүүлтэй, Сүхбаатар, Орхонтуул, Хүдэр, Бугант, Түшиг сумдын нутгаар цасны зузаан 12-28см, цасны нягт 0,14-0,19г/см³, бусад сумдын нутгаар цасны зузаан 7-10см, цасны нягт 0.10– 0.16 г/см³ байна.

Долоо.Сум орон нутгийн талаар:

1.Баруунбүрэн сум:

2016 оны 01 дүгээр сарын 13-15-ний хооронд сумын нохой устгалын ажлыг зохион байгуулж нийт 80 нохой устгаж хогийн цэгт хаяж ариутгалаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний газрууд болон төсөвт байгууллагуудын гуанз, цайны газруудад үзлэг шалгалтыг явууллаа.

Баруунбүрэн сумын хэмжээнд 2016 онд бэлчээрийн менежмент хийх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох, газар хамгаалах, нөхөн сэргээх газар зохион байгуулалтын арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг нарийвчлан тодорхойлох ажлын судалгааг гаргах ажлыг хийж байна.

Тус сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын мал зүйч, малын эмч, хүний эмч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 133 малчин өрхөөр тойрч цаг үеийн ажил байдалтай танилцан, хүн эмнэлэгийн үйлчилгээг үзүүллээ. Өвөлжилтийн талаархи мэдээллийг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар болон Онцгой байдлын газарт хүргүүлж 80 тонн өвс, 20 тонн тэжээлийн захиалга өгөөд байна.

2.Ерөө сум:

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдөрхуралдаж төсвийн тодотгол, газрын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, журам, согтууруулах ундаа зарж борлуулах зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн хүсэлтээр архи худалдаалахгүй өдрийн талаар, гэр хороололд байрлалтай тусгай зөвшөөрлийг хязгаарлах хүсэлтийг тус тус хэлэлцүүлээ.

Ерөө сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэсэгтэй хамтран "Ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг иргэдтэй" уулзах уулзалтыг 2016 оны 1 дүгээр сарын 15 ны өдөр зохион байгуулан, нийт 120 гаруй жолооч нар хүрэлцэн ирж оролцсон бөгөөд ойн анги, цагдаагийн ажилтнууд хамтран шинээр гарсан хууль тогтоомжийн талаарх мэдээлэл сурталчилгааг хийн, гарын авлага тараалаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газартай хамтран сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 70 дугаар тогтоолын хэрэгжилттэй танилцах зорилгоор 2016 оны 01-р сарын 14-ний өдөр Соёлын төвд тус суманд үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлүүдийг хамруулан уулзалт зохион байгууллаа. Тус арга хэмжээнд сумын Цагдаагийн хэсэг, нөхөн сэргээлт хийсэн нөхөрлөлүүд, нийт 100 гаруй иргэд оролцлоо. Зөвлөгөөнөөр холбогдох төрийн албан хаагчид мэдээ мэдээлэл хийж, нөхөрлөлүүд тайлангаа тавьж, мөн тэдний санал хүсэлтийг сонсож, шийдвэрлэх арга замын талаар санал солилцлоо.

3.Зүүнбүрэн сум:

Зүүнбүрэн цаг уурын харуул нь 2015 оны ажлын үр дүнгээр аймаг болон улсдаа тэргүүлээ.

2016 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр аймгийн аварга шалгаруулах бөхийн барилдааныг зохион байгуулж 100 гаруй бөхчүүд барилдан аймгийн арслан Н.Баярбаатар, сумын цолтой бөхчүүдийн барилдаанд Орхонтуул сумын заан Н.Оргилбаатар нар түрүүллээ.

Монгол Улсын үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ойг тохиолдуулан ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн сурагчдын дунд үндсэн хуулийн тухай сургалт, "АХА" тэмцээнийг зохион байгуулж нийт 40 гаруй сурагчид хамрагдсанаас 5-р ангийн сурагч Б.Сансармаа, Э.Анар нар тус тус шалгарлаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас худалдаа үйлчилгээ эрхлэдэг 4 газар, 2 аж ахуй нэгж, 1 цайны газар, төр төсвийн 3 байгууллагуудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний чанарыг шалгаж илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан, хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг устгаж, хугацаа дуусах дөхсөн бүтээгдэхүүнд үнийн хямдрал зарлуулан борлуулах арга хэмжээ авч ажиллалаа.

Мөн“Цагаан сар -2016” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 200 гаруй иргэн төмс, хүнсний ногоо, цагаан идээ оёмол бүтээгдэхүүнээр оролцож 575 кг ааруул, 95 кг шар тос, 201 кг цагаан тос,103 кг хайлмаг, 15 кг өрөм, 600 л литр сүүгээр оролцон 2,8 сая төгрөгийн борлуулалт хийлээ.

4.Жавхлант сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас 2015 оны ажлын үр дүнд дүгнэлт хийх, 2016 онд баримталж ажиллах бодлого зорилтоо тодорхойлох зорилгоор удирдах ажилтаны зөвлөгөөн болон төрийн захиргааны албан хаагчдын зөвлөгөөнүүдийг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын 2016 оны А/08 тоот захирамжаар сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх ажлын үр дүн, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор ажилтан албан хаагчдын үр дүнг сар бүр дүгнэх журмыг баталлаа.

Монгол Улсын ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд заасны дагуу сумын Засаг даргын 2016 оны А/07 тоот захирамжаар нийт 195 ахмад настныг 41 аж ахуйн нэгж байгууллагад хуваариллаа.

“Болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх” бэлэн байдлыг хангах тухай сумын Засаг даргын 02 тоот албан даалгаварын хэрэгжилтийг ханган ажиллаж төрийн захиргааны албан хаагч, байгууллагын дарга эрхлэгч нар хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж байна.

Сумын Засаг даргын баталсан 01 тоот удирдамжийн дагуу сумын төвийн айл өрх,гудамж талбайн хог хаягдлыг ачиж зайлуулах ажлыг зохион байгуулж, Моностой 2-р багийн Буйлааст, Моностой, Эрдэнэ, Бумбат 1-р багийн Хан жаргалант, Ханан, Улаан Чулуут гудамны нийт 76 айл өрхөөс үүсгэсэн 34 тн хог хаягдлыг ачиж зайлууллаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх кассын машиныг хэрхэн ашиглах журам, шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор сургалт зохион байгуулж, иргэд олноор цуглардаг 13 байршилд зарлал, зурагт хуудас байрлуулан иргэдэд мэдээлэл өгч ажиллалаа.

5.Мандал сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Бичил уурхай эрхлэгч иргэдийн дунд “Мандал хишиг хайрхан” ОНӨҮГ-ын үйл ажиллагааны талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Тус суманд өвөлжилт хүндэрч болзошгүй байгаа тул Мандал сумын засаг даргын баталсан удирдамжийн дагуу сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг Төмөрзамчдын 1-р баг, Ширхэнцэгийн 2-р баг, Баянсуудлын 3-р баг, Хэрх 4-р баг, Түнхэл 5-р баг, Тарни 8-р багийн 132 малчин өрх айлаар орж өвөлжилтийн байдалтай танилцлаа. Мөн үндэсний боловсруулах үйлдвэрт түүхий эд тушаасан 267 малчны урамшууллын материалыг хүлээн авч аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ.

“Өвлийн хүлэмж зоорийн цогцолбор аж ахуй”-г хөгжүүлэх, өвлийн хүлэмжийг хэрхэн ашиглах талаар 9 бүлгийн 32 өрхийн тариаланчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, санал бодлоо солилцлоо. Мөн Бүтээгдэхүүний борлуулалтанд маркетингийн нөлөө сэдэвт сургалтыг зохион байгуулж, 20 өрхийн тариаланч хамрагдлаа.

6.Орхон сум:

Тайлант сард сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сумын эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, сумын Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, сум хөгжүүлэх сангийн тайлан, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажлын тайланг танилцуулж, сумын эдийн засаг нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэлэлцэн баталлаа.

2014 онд арьс шир бэлтгэн үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчдын урамшууллын олголтын судалгааг гарган нийт 61 малчны материалыг бүрдүүлэн “Мал хамгаалах сан”-д хүргүүлсэнээс 39 малчин өрхийн урамшуулалаа авлаа. 2015 онд үндэсний үйлдвэрт арьс шир тушаасан 19 малчин өрхийн 52 баримтыг хүлээн авч нэгтгээд байна.

Ерөнхий боловсролын сургуулиас ажлын байран дээр багш нарын мэргэшил ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Мэдээлэл харилцаа технологийн мэдлэгийг дээшлүүлэх нь”, “Шинэчилсэн хөтөлбөрийн арга зүй”, “Татвар бидний амьдралд” сэдэвт 3 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 54 багш, ажилчдыг хамрууллаа.

7.Орхонтуул сум:

Тайлант сард төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг иргэн бүрт хүргэх зорилгоор улирал тутам зохион байгуулдаг “Мэдээллийг иргэн бүрт” арга хэмжээг Баянцогт 2-р багийн иргэдийг хамруулан зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд сумын төвийн Орон сууц, Дэл, Бор толгой, Туулын дэнж хорооллын нийт 155 өрхийг Тамгын газрын 2015 оны товч тайлан бусад мэдээллээр хангалаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Хонгор-Овоо 3-р багийн иргэдэд “Иргэдээ сонсох өдөр” арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд тус багийн 35 өрхийн төлөөлөл оролцож Тамгын газрын 2015 оны товч тайлан, цаг үеийн мэдээ мэдээлэл болон шинээр хэрэгжиж байгаа НӨАТ-ын тухай хуулийн талаар зөвлөгөө мэдээлэл сонсож, өөрсдийн сонирхсон асуултанд хариулт авлаа. Өвөлжилт хүндэрч болзошгүй байгаа талаар малчин, мал бүхий иргэдэд анхааруулж шаардлагатай мэдээллийг өглөө.

Бага насны хүүхдийн осол, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, багш, хүүхдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, багштуслах багшийн ажлын хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор тус сумын цэцэрлэгийн анги бүлгүүдийг камержууллаа. Тус ажлыг суманд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Суварган тамир”ХХК-ийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэлээ.

8.Сант сум:

Тус сумын иргэдийн түлээний хэрэгцээг хангах 2016 оны эрхийг нээж сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар түлээ 2500м³, хэрэглээний мод 1500м³бэлтгэхээр баталлаа.

Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөр, Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, анхан шатны эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Мөнгөн өвөл-салхины амт” сэдэвт 14 хоногийн аяныг иргэд, аж ахуйн нэгж албан байгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулж “Эрүүл орчинг бид бүрдүүлцгээе” уриан дор сумын хэмжээнд халтиргаа гулгаа ихтэй зам дагуух газруудыг цэвэрлэлээ. Энэхүү арга хэмжээнд нийт 100 гаруй иргэд хамрагдлаа.

Эргэлтийн эмийн сангийн ажиллах журмыг үндэслэн 2016 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн сумын эргэлтийн эмийн санг ажиллуулж иргэдэд шаардлагатай эмийг бөөний үнээр цаг алдалгүй нийлүүлж байна.

2016 оны 01 сарын 22-ны өдөр “Сантад үйлдвэрлэв”,“Цагаан сар 2016” үзэсгэлэн худалдааг “Сумандаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрэглэцгээе “ уриан доор зохион байгуулж 22 иргэн аж ахуйн нэгж байгууллага оролцож 86 төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулж, дунджаар 3.8 сая төгрөгийн борлуулалт хийлээ.

Мөн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд “Онцлох сүү сүүн бүтээгдэхүүн “, “Онцлох хүнсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн”, “Жижиг дунд үйлдвэрлэлийн шилдэг бүтээгдэхүүн “ гэсэн 3 номиннацаар шалгаруулалт явуулж шилдэг үйлдвэрлэл эрхлэгчдээ шагнаж урамшууллаа.

9.Сайхан сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас байгууллага, хамт олны чөлөөт цагийг цэвэр агаарт зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор “Цасны баяр-2016” арга хэмжээг зохион байгуулж, 15 аж ахуйн нэгж байгууллагын 120 гаруй тамирчид спортын 3 төрлөөр өрсөлдлөө.

“Оюуны давалгаа-2” уран илтгэлийн уралдааныг 2 дахь жилдээ 2016 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгууллаа.

Цас их орж хүйтэрч байгаатай холбогдуулан төв суурин газрын өвөлжилттэй танилцах, эрчим хүчний тасалдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газраас төр, төсвийн байгууллага, СӨХ, “Гавшгай-Ус” ОНӨӨТҮГ-ын цахилгаан, дулааны шугамын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийлээ.

Сумын гэмт хэгээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран Номгон тосгоны иргэдэд“Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт хичээл, архи, тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт зохион байгууллаа.

10.Цагааннуур сум:

Монгол улсын засгийн газрын 2014 оны 326 тоот тогтоол, аймгийн засаг даргын 2015 оны А/75 тоот захирамжаар суманд санхүүгийн албыг байгуулан төр төсвийн байгууллагын нягтлан бодогч нарыг шинэчлэн томиллоо.

Мөн сумын засаг даргын тамгын газрын бүтэц орон тоог аймгийн засаг даргын 2015 оны А/475 тоот захирамжаар шинэчлэн тогтоож холбогдох албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, баталгаажууллаа.

Сумын Цагдаагийн алба, Байгаль орчны алба хамтран сумын төвийн нийтийн эдэлбэр газрын орчны цэвэрлэгээг 10.0 га-д хийж 4 тн 2 портер хог, гудамны хөлдсөн мөсийг цэвэрлэлээ. 2016 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 40м³ модны эрхийн бичгийг иргэдэд олгоод байна.

Хүүхдийн Өйүдүйтээс “Тогоочийн нэг өдөр” амталгаат нээлттэй өдөрлөгийг 2015.11.14-ийн өдөр зохион байгуулж, эцэг эхнэр 100 гаруй өдөр илэцлээ.

Нийгмийн ажиллагааг зохион байгуулах зорилгоор “Цагаан-сар 2016” үзэсгэлэн зохион байгуулж, 2016.01.25-27-ийн өдөр зохион байгуулж, эцэг эхнэр 100 гаруй өдөр илэцлээ.

12.Хушаат сум:

Сумын Засаг даргын Тамгын газрын барилгын засвар, Эрүүл мэндийн төвийн бохирын шугам засвар зэрэг ажлын зураг төсвийг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн 2016 оны худалдан авах ажлын үнэлгээ хийх ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

Тус суманд улаан бурхан өвчний гаралт ихэссэнтэй холбогдуулан сумын Засаг даргын захирамжаар 1 дүгээр сарын 18-24-ны өдрүүдэд 7 хоногийн хугацаанд нийтийн үзвэр үйлчилгээ, боловсролын үйл ажиллагаа явуулахыг хориглолоо.

Сумын Эрүүл мэндийн төвөөс “Улаанбурхан, салхин цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай” сургалтыг зохион байгуулж, 50 гаруй иргэнийг хамруулан гарын авлага сурталчилгааны материалыг 500 гаруй хүнд тараалаа.

Тайлант сард сумын нийт 45 өрхөд 222м² түлээний модны эрхийн бичгийг олгож 312.0 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүллээ.

13.Хүдэр сум:

Аймгийн Засаг даргын 2015 оны А/71 тоот Цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаалгах тухай сумын Цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 13 иргэнд мөнгөн төлбөр төлөх тухай мэдэгдэл хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж байна.

Сумын Засаг даргын Тамгын газраас “Mobinet”ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Хүдэр сум интэрнэтэд бүрэн холбогдож, цаг үетэй зэрэгцэн мэдээлэл авч ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2015 оны А/160 тоот захирамжын хэрэгжилтийг хангаж, тус сумын Засаг даргын Тамгын газраас 2015 оны жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгууллаа. Тооллогын дүнгээр 29172 толгой мал тоологдож өнгөрсөн оноос 1768 толгойгоор өссөн. Үүнд Адуу 2135, үхэр 7106, хонь 11471, ямаа 8458 толгой тус тус тоологдлоо.

Мөн цэвэр эрлийз мал 3517 тоологдсон нь өнгөрсөн оноос 300 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна.

14.Түшиг сум:

Тус сумын Засаг даргын 2015 оны Б/28 тоот захирамжаар Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн 2015 оны жилийн эцсийн тооллогын үйл ажиллагааг зохион байгуулан явууллаа. Тооллогын үйл ажиллагаанд 23 төрийн албан хаагч, 3 тээврийн хэрэгслийг дайчлан, сумын Засаг даргын нөөцийн зардлаас нийт 952.8

мянган төгрөг зарцууллаа. Тооллогын дүнгээр сумын хэмжээнд 43114 толгой мал тоологдож, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,4 хувиар өссөн байна.

Түшиг сумын Засаг даргын 2015 оны А/75 тоот захирамжаар өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар цасны зузаан хунгар газартаа 17 см, хээр талдаа 12 см байна. Төв уурын зуух 14 хоногийн нүүрсний нөөцтэй, өөрийн галалгаатай Засаг даргын Тамгын газар, Соёлын төв 14 хоногийн түлээний нөөцтэй халаалт дулаан хэвийн байна. Малын хорогдол байхгүй.

Монгол Улсын шинэ “Үндсэн хууль” батлагдсаны 24 жилийн ойн хүрээнд 2016 оны 01 сарын 13-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газраас төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Үндсэн хуулийг сурталчлах ажлыг зохион байгууллаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР